

МОНГОЛ МАЛЧ УДМЫН ХҮМҮҮЖИЛ, ӨНӨӨГИЙН БИДЭН

Д.Хүүхэнбаатар

Монгол улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх ухааны сургууль, Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Хүн төрөлхтөн нүүдэллэн, суурьшин амьдрах хоёр аж төрөх аргыг бий болгожээ. Монголчууд тэнгэр, байгаль орчинтойгоо малаараа холбогдож хүнлэг, энэрэнгүй ёсоор амьдарч, малч хүний хүмүүжил олгодог байлаа. Гэтэл суурьшил нь нэг дороо шавалдан амьдрахын эрхээр бие биедээ чоно бололцож, элдэв гайт өвчин эмгэгт үй түмээрээ нэрвэгддэг бөгөөд үхэл, мөхөл рүү алхам тутамдаа дөхөж байдаг. Өнөөгийн Монгол нүүдэл суурьшил хослосон орон болсон нөхцөлд яаж нүүдлийн соёлоо малаа аварч, малч удмын хүмүүжлийг суурьшлийнханд олгох арга зам, уламжлалын тухай өгүүлжээ.

Түлхүүр үг: Занданшуулсан шарил, “Иргэн”, соёлт хүн, гэгээрсэн хүн

Үүх түүхээс үзэхэд дэлхийд хосгүй, бэлчээрийн сонгодог мал аж ахуйг гагцхүү монголчууд бий болгожээ. Таван хошуу малыг хослон эрхэлж, энэ байгаль цаг уур, эрс тэс 4 улирлын нөхцөлд хэдэн мянган жилд авч ирсэн нь гайхамшиг бөгөөд дэлхийд хосгүй гэхээс өөр аргагүй. Гэтэл мал аж ахуйгаа шинжлэх ухааны үүднээс тайлж таниж тайлбарласан нь тун хомсхон санагдана. Өрнөдийнхөн болохоор мал аж ахуй гэхээр зэрлэг бүдүүлэг, хоцрогдсон гэдгээр монголчууд малчид болохоор өөрсдий нь ердийн амьдрал, аж төрөл учир онцгойд үздэггүй явсаар иржээ. Нүүдэлч малчин монголчуудыг, мал аж ахуйг байгаль л бүтээсэн, байгалийн сонгодог бүтээгдхүүн. Чухам яагаад таван хошуу мал бий болов гэдэг нь сонин. Зэрлэг амьтдыг байгаль цаг уурын энэ өвөрмөц нөхцөлд гаршуулж, гэршүүлж, амьжиргааны голлох салбар болгосон нь тэдний зэрлэг өвөг нь энэ л хатуу ширүүн эрс тэс байгалийн амьтад байсан учир тахиас монгол адуу, хавтгайгаас 2 бөхт тэмээ, зэрлэг үхрээс монгол үхэр, аргалаас хонь, янгираас ямаан сүрэг үүсгэж гэрийн мал аж ахуй бүрэлджээ. Монголчууд гэхдээ малыг суурьшмал нөхцөлд биш, тусгай тордлого төдийлөн шаардахгүй, байгальтайгаа зохицсон бэлчээрийн мал аж ахуй болгож чадсан онцлогтой. Тусгайлан орон байр, бордоо тэжээл, усан хангамж, хүнээс их хүч, хөрөнгө шаардахгүйгээр мал нь өөрөө өөрийгөө аван явж өсөж үржиж эзнийхээ хэрэгцээг хангадаг нэг ёсны үйлдвэр ажээ. Малыг байгалаас нь хөндийрүүлэлгүй бас зэрлэг овгийнх нь өлчир тэсвэртэй, бядлаг чанар, хөдөлгөөнтэй нөхцөл байдалд дасаж зохицож чаддаг, бие бялдраар жижиг ч гэсэн хамгийн шимтэй чанарлаг шинжийг үлдээж гэршүүлснээр бэлчээрийн сонгодог мал аж ахуйн гайхамшгийг бүтээжээ. Малыг таван эрдэнэ гэдэг нь гүнзгий утга учиртай. Малын мах сүү нь ууж идэх, өмсөх зүүх ойрын хэрэглээний зүйл төдийгүй элүүлжүүлэх, анагаах эмийн увидастай. Мал аж ахуй нь харилцаа холбоо тээврийн хэрэгсэл зүтгэх хүчин болдог. Үүний үүргийг бод мал буюу адуу, тэмээ, үхэр, гэр зуурын өдөр тутмын ойрын хэрэгцээг хангаж байдгий нь бог буюу хонь, ямаа гэж ахуйд гүйцэтгэх үүргээр нь ялгаж үздэг. Адгууснаас хүнд хамгийн ойр амьтан бол нохой. Чононоос гэрийн болгосон нохой нь мал сүргээ, гэр хотоо хамгаална. Хонь мал сүргээ хариулах нь ч бий. Анч нохой, хоточ нохой гэж онцгойд үзнэ. Монголчууд морь нохой мэт зүтгэнэ гэж ярьдаг нь тэдгээр амьтдын аж ахуйдаа эзэндээ гүйцэтгэдэг үүргий нь онцолсон хэрэг. Халуун, хүйтэн хошуутай мал гэдгийн учир нь сайн, муу мал гэсэндээ биш, жилийн ямар улиралд яаж хэрэглэх, хэдийд хэрэглэвэл зохимжтой, илчлэг, ямар малын махыг хэдийд борцолж хадгалахад ашигтай,

амт шим нь сайн байдаг зэрэг олон зүйлийг харгалзаж өгсөн болов уу? Ямааг өвөл идшинд төдий л хэрэглэдэггүй тэмээг идшинд их хожуу хэрэглэсэн бөгөөд ядарч зүдэрсэн цагтаа судсыг нь ханаж халуун цусы нь сорж тэнхэрдэг байсан баримт бий. Ямааны махыг урин дулаан цагт хэрэглэдэг, сэрүүн чанартай, тэмээ ямааны махаар борц хийхэд тохиромжтой, шингэц сайтай, хуршиж мууддаггүй, үхрийн борц хийдэг боловч цаг улирлыг нь маш тааруулдаг, үхрийн хуршсан борц хор болдог гэж үздэг. Ер нь борцыг байгалийнх нь нөхцөлд хуурай аргаар хүйтэн нар салхинд болгодог сонин арга, технологтой, махыг ингэж хэрэглэх нь бусад оронд тун ховор удаан хугацаанд аян замд амт шимтий нь алдалгүй хэрэглэх шилмэл арга. Энэ нь гагцхүү нүүдэлчдэд л аян замын уртад хоол хүнсээр гачигдахгүй явах боломж олгодог. Сансарт ч сансарын нисэгч хооллож явсан билээ. Үхрийн борц давсагандаа багтдаг гэдэг үг тун учиртай үнэн үг ажгуу. Үхрийн махыг борцолж нүдээд давсаганд нь багтаах гэдэг санаанд ормооргүй юм шиг боловч борцыг нүдэж нунтаглахад тийм болдог аж. Монголчуудын мал маллагааны арга ухааныг шинжлэх ухааны үүднээс тайлсан нь тун ховор, То ван А.Амар, Ж.Самбуу нар мал маллагааны арга, ургамал ус ундны тухай өгүүлсэн авч орчин үеийн төрөл бүрийн шинжлэх ухааны үүднээс нарийвчлан тайлсан нь учир дутагдалтай. Малчид өвөг дээдсийн олон мянган жилийн туршид хуримтлуулсан бэлчээрийн мал маллагааны өвөрмөц, арвин баялаг, амьдралын практик туршлага нь шавхагдашгүй, дахин давтагдашгүй хүмүүний аж төрөх арга, хосгүй соёл билээ. Мал маллагааны судалгааны арга зүйг дараах хэдэн чиглэлээр судалж болох юм.

I. Мал аж ахуй үүссэн түүхэн нөхцөл.

II. Мал маллагааны арга зүй, мал маллах ухааныг судалсан байдал

III. Малыг бэлчээрээр (байгалтай зохицон) маллаж байгалийн амьтаны төрөлх чанарыг нь хадгалах ухаан

IV. Монгол угсаатны ургамал судлал, мэдлэг ухаан

V. Монгол ардын мал эмнэлгийн ухаан

VI. Малыг түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах технологи

VII. Мал аж ахуйн хэрэглээний тоног төхөөрөмж

VIII. Мал аж ахуйтай холбоотой тэмдэглэлт үйл явдал баяр ёслол

IX. Мал аж ахуйг тухай уран зохиол, ерөөл магтаал, дуу, шүлэг

X. Малыг ойлгох, ойлгуулах монгол ухаан

XI. Мал маллах арга ухааныг уламжлан өвлүүлэх асуудал

XII. Шинжлэх ухаан, техникийн дэвшил ба өнөөгийн мал аж ахуй, малчид

түүний ирээдүй хэмээсэн чиглэлээр юуны түрүүнд судлах нь чухал юм. Эрдэмтэн У.Лигаа нар "... Байгаль орчныг сайтар мэдэж малаа бэлчээрт ээлж сэлгээтэй маллаж, байгалийн тэнцвэрийг уламжлал болгон хадгалж чадсан угсаатан гэвэл монголчуудыг нэрлэж болно" гэсэн нь олзуурхууштай шинэлэг сонин дүгнэлт болжээ. (У.Лигаа, Г.Очирбат. Угсаатны ургамал судлалын толь. УБ., 2005. 3т) Мал аж ахуй л нүүдэлчин монголчуудыг байгаль орчноо ариун дагшин, цэвэр тунгалаг, баялаг эрдэнэсээ цөлмөн хоослоход хүргээгүй, бүхнийг мал орлож, гүйцэтгэж иржээ. Монголчууд эрт дээр үеэс өвс ургамалыг гаргуун сайн мэддэг маш өргөн хүрээтэй ашиглаж, мод, сөөг, өвсөөр янз бүрийн хөгжлийн зэмсэг хийж, оюун санааг хөгжүүлэх модон тоглоом, сав суулга, аяга тагш, шанага халбага, тэвш, авдар сав, эртэнэг, чарга, тэрэг чингэлэг, гэр орон, хашаа саравч, байшин барилга, сүм дуган барих, мал маллагааны нарийн тоног төхөөрөмж чагт, шөрөг, дэгээ оньс, уурга шилбүүр, харуул, талхи, бугуйл цалам, урхи, уяа зангилаа, сур ташуур, алх, гадас шон, хэдрэг муна, хүрз сүх зэргийг нутаг орныхоо эд зүйлсээр хийж чаддаг байжээ.

Монголчууд хүн, малын элдэв өвчнийг эмийн ургамлаар малын мах, эд

эсээр эмнэж чаддаг, ургамлаас гарсан будагч, аргаагч, идээлэгч бодисыг ашиглаж, арьс шир, байгалийн гаралтай хувцас хунарыг дээд зэргээр хийж хэрэглэж чаддаг нь онцгой сонин. Монголын нүүдэлчид малын хариулга, маллагаа уяа сойлго, уналга эдэлгээ, бэлчээр нутаг усыг нарийн тохируулж тааруулах аргыг төгс эзэмшжээ. Малчин хүн тэнгэрийн хаяа нар сар, од мичдийн мандах, гишгих, салхи, үүлний хөдөлгөөн, мал амьтны зан, төрх байдал төлөв, ургамал, ногооны гаралт, ургац, олон маргааш ойрын хоногууд төдийгүй гарах жилийн, улирах цагийн өнгийг урьдчилан шинжиж чаддагаараа бусад орон улсад тэр бүр байдаггүй ховорхон туршлага ажигч гярхай чанарыг хуримтлуулжээ. Нар шингэхийг хараад маргаашаа мэднэ. Нар улайж шингэвэл маргааш халуун, дулаан болох нь, үүлэн цаагуур шингэвэл маргааш тэнгэр муухайрна гэх мэт. Ямар иалд ямар ургамал ногоо таарах, бас цагийн байдалд тохируулахаа сайн мэддэг ч ургамал, ногооны химийн аргаар найрлагыг задлан шинжиж судлаагүй нь мэдээж. Тэмээн сүрэгт бут, бударгана, заг, шаваг, шарилж; адуунд ерхөг, хиаг, ботуул, хургалж, монгол өвс; үхэрт өлөн, хиаг, согобор, суль зэрэг сахлаг ургамал; ямаанд агь, шарилж, сонгинын төрлийн ааглаг халуун ургамал; хонинд ботгуул, ерхөг нарийн хиаг, нарийн хиаг хазаар өвс гэх мэтчилэн нарийн ангилна. Тэгэхдээ ургах ургамал ногооноос шалтгаалж харилцан адилгүй. Жишээ нь, говь хээр талд таана, хүмүүл, ган төмөр, багалуур, тэс, загсгал, бажууна их байхад хангай, нутагт эдгээртэй төстэй орлохуйц халуун чанартай, шимт олон төрлийн ургамал байх жишээтэй. Мал маллагааны нарийн арга ухааныг ойлгоогүй, мэдэхгүйн улмаас бэлчээрийн гэхээр зэрлэг, бүдүүлэг арга ажиллагаатай, хоцрогдсон гэж өнгөц хандаж, бие жижигтэй болохоор сул дорой, ашиг шим багатай гээд хаана ч байхгүй чанар чансаатай, эм, амин дэмийн чанарт нь таниж мэдэж чадалгүй, хэт өрнөдийнхөөр, “европчлох” хандлага руу хазайн гулсаж уучилшгүй алдаа хийж байсныг хэлэх хэрэгтэй. Мал аж ахуйг хөгжүүлнэ гэдгийг бэлчээрийн аж ахуйг суурьшуулах, бие бялдрыг нь томсгож үүлдэр угсааг сайжруулах нэрээр өөр үүлдрийн малаар хээлтүүлэгч тавьж эрлийзжүүлж ч үзсэн. Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон монголын гэх шинэ сайн үүлдрийн мал бий болсонгүй.

Үүлдэр угсааг сайжруулах, эрлийзжүүлэхийн ач холбогдлыг энд үгүйсгэх гээгүй. Орхон үүлдрийн нарийн нарийвтар ноостой хонь, Орхон сортын буудай бий болгож чадсаныг тэмдэглэх ёстой. Тодорхой газар, хэсэгчлэн явуулахын оронд монгол малыг бүгдийг нь эрлийзжүүлэн нэгэн дайралбаар сайжруулна гэж хавтгайруулан улмаар зохион байгуулалтын хувьд хангаж чадалгүй, зонд нь орхиж замхруулсан явдал гарсан билээ. Байгалийн амьтны шинжийг алдаагүй монгол малаа байран ажиллагаанд өссөн Европ нутгийн нарийн, нарийвтар ноост хонь, сайн угсааны гэгдэх үхэр малтай адилтгаж болох уу? адилхан хашиж байранд тэжээж бэгнэх нь зөв үү? гэж зарим судлаачид асуувал зэвшүүлж бэлчээрээр өл тэжээж авч, хүйтэн халуун аль альныг тэсвэрлэх гойд чанарыг хадгалж чадах бэлчээрийн аргаар адгуулан маллах нь илүү ашигтай болохыг бид бүхэнд хэлээд байгаа юм биш үү дээ гэсэн нь бодлогогүй үг биш. Энэ бүхнийг өгүүлэхийн учир нь мал маллах уламжлалт арга ухаан эдүгээ хэр залгамжлагдан хөгжиж байна вэ? Өнөөгийн монголынмалчид уламжлалт арга зүйгээ бүтээлчээр залгамжлан хөгжүүлж чадаж байна уу гэдэгт яагаад ч юм тун анхааралтай хандмаар байна. Орчин үеийн нөхцөлд хэрхэн авч явах, цаашид хэрхэх вэ? гэдэг асуудал зүй ёсоор тавигдаж байна. Өнөөгийн монголчуудын тэн хагасаас илүү нь хот, суурин газрынхан болжээ. Манай хотын хүүхэд, залуучууд мах идэхдээ хэнээс ч дутахгүй ч малын тухай юу ч мэдэхгүй малын бараа ч бараг хараагүй хүмүүс болжээ. Малаа мэдэхгүй хүнийг ямар монгол гэх вэ дээ. Малтайгаа байж л

Монгол байна. Ажиглахад хот газрын хүүхэд залуучууд байгаль хангайн сайхныг мэдэрдэггүй, говь гэхээр элс цөл мэтээр ойлгодог, мал адгуулж, хариулах арга барилын төсөөлөлгүй, дор хаяхад наад захын монгол үг, малтай холбоотой нэр ус ч мэдэхгүй, алаг адууг цагаантан нартай адуу, гүүг эм адуу гэх мэтээр нэрлэх нь энүүхэнд. Ахас ихсийг, нялхсыг хүндлэх хайрлах нь багасч, мал адгуусыг хайрлахыг мэдэхгүй учраас энэрэнгүй, өрөвдөх сэтгэл муутай болж монгол сайхан хүний мөс мөхөсдөж, зөвхөн хар амиа бодох атгаг хорон санаа өвөхлөж луйвар дээрэм алах түйвээх, бүлэглэн хэд хэдээр нь хядах болсон нь санамсаргүй зүйл биш ээ. Хууль дүрмээ дээдлэх, ширхэгчлэн биелүүлэх үүрэг хариуцлага, дэг журмыг сахиулах явдал суларч, анхаарал тавихаа больсонтой, ардчилал, хүний эрх гэдгийг явцуу сөрөг утгаар ойлгож хэрэглэсэнтэй шууд холбоотой. Мал маллагааны монгол уламжлалыг сэргээх, уламжлал судлалын тухай ярихын ташрамд өнөөгийн монголын шинэ үеийнхний хүмүүжлийн асуудлыг хөндсөн минь бидний өв уламжлалаа залгаж аван явж, өөртөө шингээж, шинэчлэн хөгжүүлж чадаагүйн уршиг даруй мөн гэх гэсэн хэрэг.

Монголчуудыг үр хүүхдээ хүмүүжүүлэх гол онцлог нь юуны түрүүнд эрхэлж байгаа гол мал аж ахуйтай нялх балчираас нь ойртуулж, маллагааны арга ухаан эзэмшүүлж биеий нь даалгаж хүүхдийг эрхэлж буй ажлаар нь хонь хурганы хүн болж, хурдны хүүхэд, эмнэг сургах насандаа хүрч гэх мэтээр нэрлэдэг. Тусгайлан мал маллах хичээл ном заадаггүй ч дагуулж өөрийн биеэр үлгэр үзүүлнэ. Тиймээс ч мал маллах нь хүн өөрөө хүмүүжиж, малч хөдөлмөрч ухаан суулгана. Өлгийтэйгээс нь эхлүүлээд байгальд дасгаж, байгальтай харьцаж сургана. Тэгснээр чийрэг, бие бялдар сайтай, аливааг тэсвэрлэх чанар суулгадаг. Өнөөдрийн Монголыг хүүхэд залуучуудын орон гэдэг хэрнээ жинхэнэ монгол өв уламжлалаа огоорч суурьшмал орнуудыг дууриаж эцэст нь малчин хүнийг суурьшмал орны аргаар төлөвшүүлэх гэж даган дууриаснаас хүнийг хүмүүжүүлэх үйлсэд согог суусан юм. Тэгээд ч монгол хэлэнд “Монголоо алдсан, монголгүй Орос, Хятад биш дээ” гэх мэт үгс байдаг нь өөрийн өвөрмөц хүмүүжүүлэх арга, сургалттай болохыг үзүүлж байна. Түүнээс биш бусдыг дорд үзэж, өөрсдийгөө дээр тавих гэсэн хэрэг биш. Чухамдаа Монгол сурган хүмүүжүүлэх ухаан бол хүнийг бие дааж өөрөө өөртэйгөө авч явахад сургах, бусад хэн нэгний хараат байдалд бус бодьгал чанарыг бүрэлдүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл биеэрээ үлгэрлэн дагуулахад, биеэ авч явах ухааныг нүдэн дээр нь харуулан сургахад орших аж. Гэтэл энэ ухаан сүүлийн үед бусдыг шүтэх, өөрийгөө голох, гаднын нөлөөнд өөрийн эрхгүй даган бишрэх, хуулан дууриаж монголоо алдахад хүргэжээ. Өнөөгийн монголын хот орны хүүхдүүд монгол царайтай, монголоор ярьдаг хэдий ч ёс суртахуун, хүмүүжил нь монгол биш болж байгаа нь оршиж буй амьдралын гадаад дотоод нөхцөл, нөлөө орон зайтай холбоотой. Сүүлийн 15-20-иод жилд хүүхэд залуучууд, залгамж үеийнхэндээ хандах хандлага нь тэднийг боловсролтой болгоход чиглүүлээд хүмүүжүүлэх тухайд анхаарлаа сулруулжээ. Монголчууд мэдлэг боловсролыг хүмүүжил, ёс суртахуунтай нягт холбож үздэг, хэрэгжүүлдэг. Жинхэнэ хүн болоход боловсрол шийдвэрлэх рольтой юу? эсвэл хүмүүжил, зөв ёс суртахуунд уу? гэдэг асуудал өөрийн эрхгүй тавигдаж байгаа нь үнэн бөгөөд чухамдаа хүмүүжил, ёс суртахууныг эн тэргүүнд эрхэмлэн хүн шиг хүн болгохоос эхлэх ёстой. Эрхийг сурахаар бэрхийг сур! гэсэн ардын мэргэн сургаал нь гүнзгий нарийн учиртай. Ажил, хөдөлмөрийг хар бор гэж голдоггүй, мал дагавал ам тосдоно гэдэг зарчимтай.

Социализмын гэгдэх болсон үед багагүй юм хийснийг хэлэхгүй өнгөрч болохгүй. Мал ау ахуй, газар тариалан, үйлдвэр уурхай, барилга байгууламжид ажиллах шинэ залуу залгамж үеэ малчины сургууль, илгээлтийн эзэд төрөл

бүрийн ТМС-ээр бэлтгэж их, дээд, техникумын бага курсын оюутнуудыг усжуулах, хашаажуулах, үр тариа, хүнсний ногоо, тариалах, хураахад тогтмол ажиллуулж ажлын арга барил эзэмшлж, хамтач нөхөрсөг, хүнлэг, чухамдаа амьдрах ухаан, төрдөө үнэнч түмэндээ түшигтэй хүн болгох гэж зохих амжилтанд хүрсэн билээ.

Судлаач эрдэмтэн Б.Сумъяагийн ажигласанаар (Соёл гэдэг зөвхөн урлаг, уран сайхан биш. ЗГМ сонин.1996.VI №117(557) Чингисийн морины уяа гэгдэх цагаан пайлуур элэгдэн мэдэгдэх төдий болсон байхад “монгол малчны аж төрөхүй төдийлөн өөр болоогүй нь гайхалтай” гэсэн нь малчны амьдрал хоцрогдсон гэдэг утгаар хэлээгүй, харин бэлчээрийн мал аж ахуйг эрхлэх уламжлалт дэвшилтэт сонгомол арга ухаан, их соёл, хүмүүжилболохыг улмаар шинэчлэн хөгжүүлэхийн чухлыг анхааруулсан хэрэг юм. Малчид урьдын адил нүүдгээрээ нүүж, малаа малладагаараа маллаж, хишиг буяныг хүртдэгээрээ хүртэж, байгалийн хатуу ширүүнийг сөрдгөөрөө сөрж, И.Чимэддоржийн шүлэглэснээр “малаа яаж маллахыг марксизмаар заалгахгүй” өдий хүрснийг хэмээх нь нүдээ олсон гэмээр. Ажил үйлсийн бүтээл нь хүний итгэл, зүтгэл, сэтгэлээс шалтгаалдаг болохоор нүүдэллэн аж төрөх нь байгаль дэлхийтэйгээ адил бат тогтвортой бөгөөд хөдөөгийн малчдын ажил үйлс, сэтгэлгээ нь ч тийм юм. Соёл иргэншил гэж нэг юм шиг үздэг нь огт буруу. Соёл гэдэг нийгмийн амьдралын бүх хүрээг хамарна, түүнээс гадуур зүйл байхгүй. О.Шпенглер (Герман) их эрдэмтний хүний нинжин сэтгэлийн амьд бие нь соёл, харин занданшуулсан шарил нь иргэншил” хэмээн тэр үед Европт нүүрлэж аюул болсныг онож хэлсэн байдаг. Соёл гэдэг бол хүн төрөлхтөний амьдрах хөгжих, амин сүнс, арга зүй, иргэншил гэдэг нь түүний оршин тогтнож буй хэлбэр, өөрөөр хэлбэл соёл нь үйлдвэрлэлийн арга, иргэншил байгаа дүр төрх бөгөөд агуулга хэлбэрийн эсрэг тэсрэгийн нэгдэл болно. Нүүдлийн соёл иргэншил, суурьшмал соёл иргэншил гэх нь зохимжгүй, нүүдэлчид суурьшмал амьдралтай биш бөгөөд иргэншлийг зөвхөн суурьшмал амьдралд хамааруулж болох бөгөөд эртнээс монголтой хөрш оршиж суурьшмал ганцхан орон Хятадыг иргэн хүн, хятад иргэн гэдэг байсан. Харин манай орны баруун, зүүн, хойд талаар нүүдэлчин анчин, гөрөөчин, хөршүүд байсан. Иргэн гэдэг нь ард, зон гэсэн манж үг бөгөөд хятадын Дундат иргэн улсаас хойш монголд байсан хятад хүнийг “иргэн” гэх болж, сүүлдээ нийт хятадуудыг нэрлэх болжээ. Энэ үг цаад утгаараа “ирмэл хүн” (харийн) гэсэн утгатай ч байж болох юм. Гэтэл одоо болоход монголчууд өөрсдийгөө “Монголын иргэн”, “ард иргэн” гэх болж монгол хүн, монголын ард гэх нь ховордож “Үндсэн хуулиндаа “дээдэлсэн” байх нь хачирхалтай санагдана. Түүхэн үүднээс үзэхэд монголчуудын гарвалыг хятадын харгис үзэлт хаад, түүхчдийн монголчууд “манай нэг овог хойд газар очиж суугаад тэр газраа мал аж ахуй эрхлэн, сүүлд тусгай хэлтэн болсон” гэснийг зөвшөөрч байгаа хэрэг болох нь уу? Хятад улс монголчуудыг биш, тэднийг уусгаж аван хайлах, гол нь Монголын газар нутаг, баялагт л шунаж байсан нь эртнээс бөгөөд бүр хожуу XX зууны эхээр “Иргэнийг шилжүүлэн суулгаж хязгаарыг бэхжүүлэх” бодлого гэгчийг явуулж эхлээд Өвөр монголд тариа тарахаар оруулсан хятад иргэдийн засаг захиргааны байгууллага, товчоо, хоршоо зэргийг бий болгосон нь үүний тод илрэл мөн. Ар Монголд олон зүйл судалгаа явуулж, хятад иргэдийг зугуухан, арай хожуу эхэлсэн ч мөн л дээрх бодлогын үргэлжлэл байлаа. Тиймээс ч Монголд Ханддорж Чин вангийн хошуу тэргүүлэн хятадуудыг хөөж гаргах тэмцэл өрнөсөн нь монголчуудын үндэсний эх оронч үзлийг идэвхжүүлсэн юм. Түүхэн туршлагаа эргэн харахад өнөөдрийн монголд боловсролтой болгоно гэж хөл алдан хөөцөлдөж өдий төдий гадаад дотоодын их дээд сургууль төгссөн төрөл бүрийн диплом өвөртөлсөн мэргэжилтнүүд олширсон ч мэдлэгээ яаж хэрэглэх, хэрхэн

хэрэгжүүлэх ухаан чадавхи эзэмшээгүй нь тэдэнд сайн хүмүүжил олгож чадаагүйтэй холбоотой. Хүүхэд залуучуудын өмнө боловсрол бус, хүмүүжил хүн чанарын түмэн бэрхшээлд бүдрэхгүйн тулд биеий нь бэлдэх хэрэгтэй. Ажил хөдөлмөр, аж ахуйг эрхэлж техник мэргэжлийн сургууль, техникум, түр сургууль, курс, дамжаагаар бэлтгэж, тэдэнд ажлын дадлага, амьдралын суурь боловсрол (амьдрах ухаан), хүмүүжил олгодог зарчим алдагдсанаас ийм нийгмийн ямар ч идэвхгүй, үлгэн салган, хорон муу санаа сэтгэл өвөрлөж, хамгийн үзэшгүй муу муухайг баригч нийгмийн шаарууд бий болжээ. Боловсролгүй ч гэсэн хүмүүжилтэй хүн нийгэмд амьдраад байж болно. Хичнээн боловсролтой ч хүмүүжилгүй бол хулгай дээрэм, нийгмийн хууль дүрэм, хэв журмыг зөрчигч гамшиг таригч нийгэмд хэрэггүй хорт хогууд болдог нь эдүгээ хогууд болдог нь эдүгээ нэгэнт тодорхой харагдаж байна. Ийм залуучуудтай Монгол улс хаашаа явж байна вэ? Үүнд монголчууд дасчихсан гэж зарим нь хэлж байх юм. Тэгвэл монголоо гаргуунд нь орхино гэсэн үг үү? Энэ хэзээ ч байж болохгүй ухаан. Гэхдээ манай бүх хүүхэд залуучууд ийм болчихсон гэсэн үг биш.

Ахмад үе, эцэг эх, багш нарынхан үлгэр дууриал, сургаалийг дагаж хүн шиг хүн болж эх орныхоо хөгжил цэцэглэлт сайн сайхан амьдралын төлөө зүтгэж, алдаа согог, гажуудал, төр засгийн дутагдалтай тэмцэж, шүүмжлэн тусалж сэтгэл зүтгэлээ гаргаж яваа залуу үеийнхэн давамгайлж байна гэж бардаагаар хэлж болно. Тэдэнд бид ирээдүйгээ даатгаж сайн сайхан итгэл найдвар өгч, хүмүүжүүлэн өсгөж онцгой анхаарал тавьж байна. Энэ талаар үеийн үед ажил үйлсийнхээ төлөө тэмцсээр иржээ. Хувьсгалын жилүүдэд хувьсгалч, эх оронч үзэлтний социалист нийгмийн шинэ хүнийг хүмүүжүүлэх, хүмүүнлэг ардчилсан нийгмийн идэвхтэй шинэчлэгч, өөрчлөн байгуулагчдыг бэлгэсээр иржээ. Төр, засгаас тухайн үе бүрт онцлон анхаарч их зүйлийг хийж амжилтанд хүрч иржээ. Энд алдаж онож ирснээ ч нуух юун. Хувьсгалын ардчилсан шатанд залуусаа хэлмэгдүүлэх, гадаадын тагнуул, хувьсгалын эсэргүү хэмээн хардаж, тэр үеийн нам, төр засгийн алдаа, нугалаатай бодлогыг хэрэгжүүлэх гэж турхиран хөөргөж, хуучин түүх соёлын дурсгал, сүм хийд, бурхан тахилыг эвдэн нураалгаж, судар намыг шатаалгаж, ардын сүшиг бишрэлийг доромжилж хяхан хавчиж байлаа. Социализмын үед үндэсний эх оронч сэтгэлгээтнийг үндсэрхэх үзэлтэн, Монгол Зөвлөлтийн найрамдалд харш, эсрэг үзэлтэн, сөрөг хүчин гэж хардаж сэрдэж найдваргүйд тооцож нам, эвлэлээс хөөх, ажлаас нь халах, нутаг зааж хорих цөлөх явдал ч гарч байсан нь бий. Ардчилал, шинэчлэлт хүний эрх, чөлөөт байдал нэрийн дор төр засгаа нүд үзүүрлэн дайран доромжлох, хууль ёсыг бүдүүлгээр зөрчих, нийгмийн хэв журмыг хөсөр орхиж аллага хядлага, хулгай дээрэм бүлэглэн танхайрах аймшигт хэрэг газар авч байна. Энэ нь өнөөгийн монголын дүр төрх болоход хүрчээ. Яагаад ийм болов гэдэгт ихэнх хүмүүс нийгмийн буруу гэсэн байх юм. Нийгэм бол хүн ардаас бүрэлдэн тогтоно. Нийгмийн гишүүдийн хувьд буруутай байж болох боловч ихэнх гэр бүл үр хүүхдээ сайн хүмүүжүүлж, сургадаг шүү дээ. Бодоход нийгмийн толгойд төр, засаг гэж бий. Хүүхэд залуучуудын өдий төдий олон байгууллага ажилладаг. Бас гадаад орчины нөлөөлөл гэж байдаг. Сүүлийн 20-иод жилд эцэг эхийн хүүхэддээ тавих анхаарал сулрах хандлага үзэгдэж бас ядуу зүдүү амьдрал, гачигдал зовлонгийн улмаас хүн шиг хүн болох замаасаа гарах нь бий. Мөн эцэг эхийн хөрөнгө мөнгөөр туйлж хөнгөн амьдрал хүсэгчид гарах боллоо. Багш нь сурагч, оюутандаа мэдээлэл өгөх төдий болж хүмүүжүүлэх үүргээ мартах, орхих болжээ. Сургууль бол мэдээлэл түгээдэг газар биш, мэдлэг олгох эрдэм номын газар мэдээг олгосноор мэдсэнээ эд баялаг болгох чадвартай ажиллаж хөдөлмөрлөж хүмүүжиж эд баялаг бүтээгч соёлт хүн болно. Соёлт хүн бүхэн заавал ямар нэг сургууль

төгссөн мэргэжлийн үнэмлэхтэй хүнийг хэлдэггүй, харин өндөр ёс суртахуунтай, хүнлэг чанар эзэмшсэн, эрхэлсэн ажилдаа бүтээлч ажилч хичээнгүй жирийн хүнийг л хэлнэ. Иймээс урлаг уран сайхны авъяастай, онцгой нэгнийг хэлэхгүй боловч харанхуй мунхаг байх гэсэн хэрэг огтхон ч биш гэдгийг тэмдэглэх нь зүй. Өндөр ёс суртахуунтай, цэвэр ариун хүмүүжилтэй хүнийг бий болгоход заавал боловсролоор биш, хувийн хичээл зүтгэлээр биеэ дааж эзэмших явдал юм. Өнөөгийн Монгол бол нүүдэл суурьшил хосолсон орон болжээ. Үүсэл, гарал, байгаль түүхийн орчин, соёл ахуйн нөхцөл, сэтгэл санаа, зан төлөв, хүсэл эрмэлзлэлээрээ ялгаатай хөдөөгийнхөн, хотынхон гэдэг хоёр хэсгээс бүрэлдэж байна. Энэ хоёр харилцан шүтэлцээтэй бас зөрчилтэй бөгөөд энэ байдлыг харгалзан үзэлгүй бусад орныг үлгэр болговол яваандаа аргалж болшгүй байдалд орж мэдэх юм. Юуны өмнө хөдөөгийн хөдөлмөрчдөд, хөдөөд орчин үеийн техник, шинжлэх ухааны соёлыг хотоос нэвтрүүлэх, хотынхонд монгол зан заншил, ёс суртахуун, малч удмын хүнлэг хүмүүжлийг оруулж эзэмшүүлэх, ялангуяа хотод төрж өссөн хүүхэд залуучуудад монгол нутаг хангайгаа мэддэг, малаа мэддэг мэдлэг, ухаан суулгахад онцгой анхаарал тавьж дорвитой арга хэмжээ авч, үр бүтээлтэй ажиллах шаардлагатай байна.

Хүүхдийн жил “Хүүхэд манай ирээдүй” гэх мэт лозун тавиад амжилтанд хүрэхгүй гэдэг нь илэрхий харагдлаа. Бүх шатны сургуулиудад монголын зан заншил, ёс суртахуун, малч хүмүүжлээр хичээл заах, хотын хүүхдийг хөдөөд мал дээр гаргаж сургадаг зарчмыг хэрэгжүүлмээр байна. Хотын хүүхдүүд нохойтой ноцолдож, зарим нь муур нохойгоо дүүнлэн тамалж зугаагаа гаргаж, үхрийн гуянд хадаас шаасныг нүдээр үзээд сэтгэл эмзэглэж, зүрх хирдхийж байснаа санахад чинь монгол гэж үү? гэж эргэлзэхэд хүрч байж билээ. Өрнийн, гадныхны тэндээ газар орон, хүн арддаа зохицсон сэтгэл зүй, логикгүй (сурган хүмүүжүүлэх ухаан), түүх, угсаатны зүй, эдийн засаг зэрэг олон зүйл мэргэшүүлэх хичээлүүдийг заахдаа монголоо мартдаг гэм хэвээр байна. Бүтээлч биш даган дууриах хуулбарлан давтах нь зарчим болж монголтойгоо холбохоо мартжээ. Ямар ч мэргэжлийн хичээлийг монголтойгоо холбож зааж болно. Багш нь монголоо мэддэггүй учраас бусдыг дууриан, бүтээлч сэтгэлгээгүй тоть шиг давтаж оромдох явдал ердийн хямд төсөр хоол олж идэх хэрэглүүр болоход хүрч байна. Ийм байдалд яагаад хүрэв? Социалист нийгмийн шинэ хүнийг хүмүүжүүлэн төлөвшүүлэх тухай МАХН дөрөвдүгээр программдаа социализм байгуулах гурван үндсэн зорилтын нэг болгон дэвшүүлж байсан. Гэтэл хүссэн үр дүндээ хүрсэнгүй харин ч хараа хяналт, дэг журам суларсны улмаас ажилгүйчүүд бий болж олширон гэмт хэрэг, танхай балмад хэрэг явдал гарахын үндэс болж, хүнлэг ариун ёс суртахуунаа хөсөрдүүлэх болов. ХҮН ард жирийн хүмүүс байнгын түгшүүртэй амьдарч байна. Хүн нь хүнээ, хүүхдээ гэдэг эрхэм ёсон саарч, ардчилал, эрх чөлөө, нээлттэй улс, чөлөөт зах зээл нэрээр нийгмийн гишүүдээ зөнд нь тавьж, хүлээх үүрэг хариуцлага, сахилга бат алдагдаж эх захаа мэдэхгүй, түрүүний бөөс толгойд гарна гээч болжээ. Монголчуудын “эцэггүй хүүхдийн толгой их, эхгүй хүүхдийн гэдэс их” гэдэг мэргэн сургаал нь бат тогтсон дэг журамтай байхын чухлыг хүүхэд залуучууддаа монгол хүмүүжилтэй хүн болгохын чухлыг эрхэмийн эрхэмд үзэхээ мартсаных билээ. Өнөөгийн хүүхэд, залуучуудын эцэг эхийн зарим нь уламжлалт монгол зан заншил, хүмүүжлээ марьяж саармагжсан хоточсон хүмүүс болжээ. Ажихад хөдөөний хүүхэд залуучууд хотынхоос илүү дэгтэй даруу байх шиг санагддаг. Энэ нь мөнөөх ахуй, орчноосос тухайлбал говь ч, хангай ч бай байгальтайгаа, мал аж ахуйтайгаа шууд харилцаж, цэвэр тунгалаг агаар усыг нь хүртэж өсөж төрсөнд байгаа юм. Харин хөдөөнөөс хот, сууринд ирээд эвдрэх нь бий. Хөдөөд ч зүй бус, үйлдэл, малын хулгай гарах, түүх соёлын дурсгалыг сүйтгэж ухаж малтах, ашигт малтмал, ургамал, ой

модыг хайр найргүй түйвээх болжээ. Дээрх баримтуудыг дурьдаж байгаа нь монголчууд нийтээрээ ийм болчихсон гэж байгаа хэрэг биш, өндөр соёл, хүмүүжилтэй эрүүл, саруул хүмүүс дийлэнх олонхи давамгайлан тэргүүлж, монголын нүүр царайг дэлхийд илэрхийлж байна.

Монгол Америкийн дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойгоор ерөнхийлөгч Ж.Буш захидалдаа "... 20 жилийн дотор танай орон коммунизмаас эрх чөлөөт нийгэмд шилжих гайхалтай шилжилтийг хийж, амьд ардчилалыг байгуулж, эдийн засгаа худалдаа, хөгжил цэцэглэлтэд нээлттэй болгожээ. Та бүхэн өдөр тутмын хүчин зүтгэлээрээ үр хүүхэд, ач нартаа илүү сайхан амьдралыг цогцлоож байгаа бөгөөд Америкийн ард түмэн та бүхний тэвчээр зоригийг биширч байдаг. Улс төр, эдийн засгийн шинэтгэлүүдийг үргэлжлүүлэн хийж, Хзийн цээжинд ардчилалыг бэхжүүлж байгаагаараа танай орон бүс нутагтаа төдийгүй дэлхий даяар амжилтын үлгэр дууриал болж байна" гэсэн нь эрин цагийн шинэ Монголыг үнэлсэн үнэлгээ мөн (Ардын эрх сонин, 2007 №16 /550/). Монголчууд хөгжлийн шилжилтийн үйлсдээ алдаж, онож байгаа ч ирээдүйрүүгээ итгэл төгс, өөдрөг сэтгэлтэй замнаж байна. Ардчилсан эрх чөлөөт шинэ нийгмийг байгуулахын тулд хүнээ бэлтгэх нь эн тэргүүнд тавигдаж байгаа бөгөөд энэ нь огцом нэг мөсөн хийгдэхгүй нь мэдээж. Шинэтгэлийг хуучин хүмүүнлэг дэвшилт уламжлалаа өвлөн авч үргэлжлүүлэх, бусдын сайн туршлагыг бүтээлчээр авч урагшлах нь гарцаагүй. Социализм байгуулах гэж зүтгэж байсан тэр үед манай нам төрийн нэрт зүтгэлтэн Ю.Цэдэнбал социалист нийгмийн шинэ хүний шинжийг "хүн бүр бага балчраасаа эхлэн туйлын аж ахуйч, арвигч хямгагч, социалист өмчийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч, хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх ёстой /1978/" хэмээн тодорхойлж байлаа. Энд аж ахуйч, хөдөлмөрч байхыг тодорхойлсон бөгөөд харин тэдгээрийн ёс суртахуун, хүмүүжил, дэвшилт өв уламжлалын тухай дурьдсангүй нь учир дутагдалтай санагдана. Хүнийг ажил, хөдөлмөрөөр хүмүүжүүлэх нь гол зүйл бөгөөд дэмий хий сургаал номлох нь үр дүнд хүргэхгүй. Хөдөлмөр хүнийг бий болгосон гэдэг их сэтгэгчдийн үг яасан онож хэлсэн суут үг билээ.

Монголчууд эрт үеэс хүнийг хүмүүжүүлэх арга ухааны ном, сурах бичиг зохиож тусгай сургууль соёл арга хэмжээ явуулдаггүй, амьдрал практикаар үлгэр жишээний хүчээр биеэр нь амсуулж мэдрүүлж яс маханд нь шингээж, биеэ дааж өөрөө өөрийгөө авч явах чанарыг төлөвшүүлдэг. Сайн сайхан амьдрал хөгжил цэцэглэлтийн үндсийн үндэс бол хүн хүндээ өгөх бат итгэл гэж үздэг. Эртнээс уламжлалтай анд бололцох ёс, андгай тангараг өргөдөг байсан нь үүний тод жишээ болно. Монгол хүн тэнгэрт шүтэж байгаль дэлхий, мал адгуус, ус ургамалаа хайрлан хамгаалж аргадан тахиж ирсэн нь хүнийг хүмүүжүүлэх бодит таатай орчин нөхцөл нь бөгөөд монголчууд нэн эрт үеэс мөнх тэнгэрийн үзэл номлолыг боловсруулан Их Монгол улсын шүтээнтэй, онолжсон, нийгэм, улс төр, гүн ухаан, ёс зүй, гоо сайхны бүрэн... үндэс холбоо бүрэлдсэн гэж эрдэмтэд (Г.Гэрэлбаатар, Мөнх тэнгэр бол монгол хүний хамгийн том философийн ойлголт /ярилцлага/ "Үнэн" сонин. 2005 №054-055) үзэж байна. Бүх юмны гарал үүслийг тэнгэртэй холбож, мөнх тэнгэрт тулгуурладаг, Их Чингис хаан ч агуу их төр улсаа байгуулж, ёс зүйн хэм хэмжээгээ тогтоож чадсан нь энэ тэнгэрлэг гүн ухааны бодит биелэл байсан. Монголыг хөх тэнгэрийн орон, тэнгэр гаралтан хөх монгол гэдэг нь ч үүнээс улбаатай. Мөнх тэнгэрийн номлол нь сансар, огторгуй тэнгэр биш, эцэг тэнгэр, эх дэлхий харилцан нягт уялдаа, шийдлээр болдог гэсэн үг буюу орчлон ертөнцийн гол эх үүсвэр, ижилсэх хурд нь юм. Жирийн монгол хүмүүс, эрхтэн дархтан ч бай хойч үеэ, үрс хүүхдээ энэ л зарчмыг баримталж, амьд явахын ухаан гэж үздэг. Тиймээс ч монголчуудыг оюуны маш их чадавхитай ард түмэн

гэдэг. Мөнх тэнгэрийн сургаал нь монголчуудын бүтээсэн, нээн илрүүлсэн хүн төрөлхтөний оюуны гайхамшигт ололт, оршин тогтнохын үндэс мөн. Түүхийн урт удаан хугацаанд түмэн бэрхшээлийг даван уусаж усталгүй эдүгээ хүрч ирсэн нь монголчуудын тэнгэрлэг ухааны ач билээ. МОНголчуудын хөх цусанд оюуны их чадавхи ажиллах, удирдах чадварын ген байдаг гэж эрдэмтэд үздэг бөгөөд үүнийгээ ч түүхнээ нэг бус удаа харуулсан билээ. Өнөөгийн бид, хойч үе маань чадварлаг эзэмшиж, уламжлан хөгжүүлэх хэрэгжүүлэх явдал амин чухал болж байна. Бидэнд өнөөдөр тэнгэрээс заяасан төрмөл чанарыг хоромхон эзэмшиж хэрэгжүүлж чадахгүй байгаа нь харагддаг бөгөөд сайн удирдан манлайлагчид алсын хараатай, шургуу тууштай хүмүүс илтэд дутагдаж байна. Ийм учраас л хүүхэд залуучууд, хүн ардынхаа хүмүүжил, өндөр ёс суртахуунаа тэргүүн байранд дэвшүүлэн тавьж байгаа юм. Өөрөөр хэлбэл бодьгал /гэгээрсэн/ хүнийг бий болгоход бодь морийн сургаалыг эрхэмлэх нь чухал. Монгол удмын хүмүүжил, ёс суртахууны судлалыг хүчтэй болгож өргөн сурталчилж эзэмшүүлэх, арга зүйг тогтоон хэрэгжүүлэх төр засгийн зүгээс тавих анхаарал бодлого хэрэгтэй байна. Ер нь монголчууд бид сүүлийн 100-д жилд өвгөд дээдсийнхээ их зүйлийг мартсан, бусдыг даган сохроор хуулбарлан өөрийнхөө юмыг хоцрогдсонд үздэг, хуучны юм бүхнийг устгаж арилгах гэж ухаангүй загнасанаас болж өнөөгийн нийгэмд эх захаа алдсан, замбараагүй бузар булай үзэгдэл гарахад хүргэсэн гэж үзэж болно. Монголчууд хүнийг хүн болгох бичигдээгүй хуультай. “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа”, “эзэн хичээвэл заяа хичээнэ”, “Эх нь хээр алаг бол унага нь шийр лаг”, “Ахмадын сургаал алт”, “Ах нь сургаж дүү нь сонсдог”, “Хүн ахтай дээл захтай”, “Цэр нь цээжиндээ, бөөр нь бөгсөндөө” гэх мэтийн мэргэн сургаал үгсийг алхам тутамдаа мөрдөн дагахад сургах, нарийн дэг журмыг хатуу тогтоохоос эхлэх хэрэгтэй болжээ. Хүүхдийг хүмүүжүүлэх явдлыг бүх ард түмний үйлс болгож нөхцөл байдал бүрэлдүүлж, зохион байгуулалтын эрс өөрчлөлт хийж хууль зүйг шинэчлэн тогтоож мөрдүүлэх нь чухал байна.

Abstract: Over 83 per cent of human population have settled by now in urban centers or cedentary areas, jeopardizing the nomadic culture. This “disastrous” phenomenon is called an “inevitable” process of globalization. In reality, globalization is the result of forced unification of lifestyle. Therefore, the article contributes ideas on how to preserve the nomadic culture and way of life of the Mongols.

Ном зүй, ишлэл

1. У.Лигаа, Г.Очирбат. Угсаатны ургамал судлалын толь. УБ., 2005
2. Б.Сумъяа, “Соёл” гэдэг зөвхөн урлаг уран сайхан биш. ЗГМ соин, 1996, VI, №117 (557)
3. Ж.Бушийн захидал, АЭ, 2007 №5 (550)
4. Г.Гэрэлбаатар, Мөнх тэнгэр бол монгол хүний хамгийн том философийн ойлголт мөн
5. Ү.Нямдорж, Соёлын философи. Монголын соёл. УБ., 2004
6. Б.Батчулуун, Нийгэмшил ба нүүдлийн соёл иргэншлийн А.Э. сонин, 1996, №141 (135)